



## БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Толбо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БӨА-2023/92/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Өлгий хот  
2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын  
дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган  
Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn  
Аудитын менежер: Х.Женисбек  
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn  
Ахлах аудитор: Х.Манаргүл  
Утас: 95429524 Цахим хаяг: manargulx@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	3
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	5
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	Error! Bookmark not defined.
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	Error! Bookmark not defined.
4.1 Ерөнхий зүйл.....	Error! Bookmark not defined.
4.2 Материаллаг байдал.....	Error! Bookmark not defined.
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	Error! Bookmark not defined.
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	Error! Bookmark not defined.
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	Error! Bookmark not defined.
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	Error! Bookmark not defined.
4.5.1 Завсрын аудитын талаар.....	Error! Bookmark not defined.
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	Error! Bookmark not defined.
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	Error! Bookmark not defined.
5.1 Төлбөрийн акт .....	Error! Bookmark not defined.
5.2 Албан шаардлага .....	Error! Bookmark not defined.
5.3 Зөвлөмж .....	Error! Bookmark not defined.
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	Error! Bookmark not defined.

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgii@audit.gov.mn

ТОЛБО СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Б.ДАУЛЕТ ТАНАА

2023.08.24 № 186  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Толбо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Толбо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Хандив тусламжаар 40.9 сая төгрөгийн тавилга, машин тоног төхөөрөмж хандив тусламжаар хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.

**Аудитын гол асуудал**

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>153,864,496.71</u></b>	<b><u>233,945,235.71</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	99,926,760.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	99,926,760.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	-	99,926,760.00
31211	Төрийн сангийн харилцах	-	91,518,235.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	8,408,525.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	394,172.00	329,085.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	394,172.00	329,085.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	153,470,324.71	133,689,390.71
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	138,852,824.71	133,689,390.71
35420	Аж ахуйн материал	138,692,824.71	108,681,058.91
35440	Түлш, шатах тослох материал	160,000.00	-
35460	Хүнсний материал	-	25,008,331.80
35600	Мал амьтад	14,617,500.00	-
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,919,155,634.15</u></b>	<b><u>1,950,779,270.47</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,919,155,634.15	1,950,779,270.47
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,912,923,634.15	1,944,547,270.47
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,911,464,558.20	1,911,464,558.20
39202	Хуримтлагдсан элэгдэл	(142,574,888.57)	(182,378,879.09)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	212,185,208.25	267,441,487.25
39206	Хуримтлагдсан элэгдэл	(176,259,108.66)	(166,326,734.27)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	167,966,354.73	173,710,454.73
39208	Хуримтлагдсан элэгдэл	(109,099,380.80)	(112,611,006.35)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1,200,000.00	1,200,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,583,935.00	2,583,935.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,583,935.00)	(2,583,935.00)
39217	Ном	48,040,891.00	52,047,390.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	6,232,000.00	6,232,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	6,782,000.00	6,782,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(550,000.00)	(550,000.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>2,073,020,130.86</u></b>	<b><u>2,184,724,506.18</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>2,593,820.00</u></b>	<b>=</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	2,593,820.00	-
<b>413</b>	<b>Өглөг</b>	2,593,820.00	-
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	2,593,820.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	2,593,820.00	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>2,070,426,310.86</u></b>	<b><u>2,184,724,506.18</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,070,426,310.86	2,184,724,506.18
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,415,384,459.00	1,415,384,459.00
51101	Өмч: - төрийн	1,415,384,459.00	1,415,384,459.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(654,396,593.98)	(540,098,398.66)
51210	Өмнөх үеийн үр дүн	(654,396,593.98)	(654,396,593.98)

Толбо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

51220	Тайлант үеийн үр дүн	-	114,298,195.32
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,309,438,445.84	1,309,438,445.84
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>2,073,020,130.86</u></b>	<b><u>2,184,724,506.18</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,890,883,205.00</b>	<b>2,322,565,474.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>18,892,847.00</b>	<b>7,975,150.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	18,892,847.00	7,975,150.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	18,892,847.00	7,975,150.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	238,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	18,892,847.00	7,737,150.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,871,990,358.00</b>	<b>2,314,590,324.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,695,779,134.00	2,051,332,099.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	2,010,400,000.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	94,097,334.00	40,932,099.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,601,681,800.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	9,003,224.00	8,408,525.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,003,224.00	8,408,525.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	167,208,000.00	254,849,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	167,208,000.00	254,849,700.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,850,963,670.09</b>	<b>2,208,267,278.68</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,850,963,670.09</b>	<b>2,208,267,278.68</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,805,294,120.09	2,139,736,697.68
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,282,362,800.00	1,495,735,669.00
210101	Үндсэн цалин	1,210,803,400.00	1,132,194,503.00
210102	Нэмэгдэл	-	322,560,538.00
210104	Урамшуулал	71,559,400.00	40,980,628.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	172,604,928.00	187,510,887.00
210201	Тэтгэврийн даатгал	121,430,328.00	128,177,472.00
210202	Тэтгэмжийн даатгал	12,793,700.00	14,586,515.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,234,900.00	11,932,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,558,700.00	2,983,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	25,587,300.00	29,831,300.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	168,736,430.00	161,066,900.00
210301	Гэрэл, цахилгаан	7,809,930.00	13,468,302.00
210302	Түлш, халаалт	160,371,000.00	146,943,598.00
210303	Цэвэр, бохир ус	555,500.00	655,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	20,368,147.00	3,317,500.00
210401	Бичиг хэрэг	3,912,900.00	
210402	Тээвэр, шатахуун	4,280,350.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,770,400.00	

Толбо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210404	Ном, хэвлэл	502,500.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	570,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,331,997.00	
210408	Бараа материал акталсны зардал	-	3,317,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>87,696,500.00</b>	<b>125,544,278.20</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	484,700.00	
210502	Хоол, хүнс	83,752,200.00	125,544,278.20
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,459,600.00	
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,000,000.00</b>	<b>1,100,000.00</b>
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,100,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>140,000.00</b>	<b>-</b>
210702	Дотоод албан томилолт	140,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>920,000.00</b>	<b>6,091,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	320,000.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	6,091,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>71,465,315.09</b>	<b>159,370,463.48</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,674,500.00	79,757,700.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,923,100.00	14,164,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	65,867,715.09	65,448,462.68
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>45,669,550.00</b>	<b>68,530,581.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>38,193,330.00</b>	<b>68,529,550.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	38,193,330.00	68,529,550.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>7,378,850.00</b>	<b>-</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,378,850.00	
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>97,370.00</b>	<b>1,031.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	97,370.00	1,031.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>39,919,534.91</u></b>	<b><u>114,298,195.32</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>39,919,534.91</u></b>	<b><u>114,298,195.32</u></b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>13</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>1,777,893,024.00</u></b>	<b><u>2,273,658,225.00</u></b>
<b>1310</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,777,893,024.00</b>	<b>2,273,658,225.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,601,681,800.00</b>	<b>2,010,400,000.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		2,010,400,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,601,681,800.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>9,003,224.00</b>	<b>8,408,525.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,003,224.00	8,408,525.00

Толбо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	167,208,000.00	254,849,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	167,208,000.00	254,849,700.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,772,483,024.00</b>	<b>2,117,591,465.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,772,483,024.00</b>	<b>2,117,591,465.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,726,563,474.00</b>	<b>2,048,395,884.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,282,362,800.00	1,495,735,669.00
210101	Үндсэн цалин	1,210,803,400.00	1,132,194,503.00
210102	Нэмэгдэл		322,560,538.00
210104	Урамшуулал	71,559,400.00	40,980,628.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	172,999,100.00	187,445,800.00
210201	Тэтгэврийн даатгал	121,824,500.00	127,783,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	12,793,700.00	14,915,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,234,900.00	11,932,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,558,700.00	2,983,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	25,587,300.00	29,831,300.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	166,110,630.00	160,906,900.00
210301	Гэрэл, цахилгаан	7,809,930.00	13,468,302.00
210302	Түлш, халаалт	157,760,700.00	146,783,598.00
210303	Цэвэр, бохир ус	540,000.00	655,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	13,843,844.00	-
210401	Бичиг хэрэг	3,498,424.00	
210402	Тээвэр, шатахуун	2,142,800.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,770,400.00	
210404	Ном, хэвлэл	502,500.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	570,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,359,720.00	
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	83,882,300.00	150,269,610.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	484,700.00	-
210502	Хоол, хүнс	79,308,000.00	150,269,610.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,089,600.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,000,000.00	1,100,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,100,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	446,000.00	-
210702	Дотоод албан томилолт	446,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,157,500.00	6,091,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	557,500.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		6,091,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	4,761,300.00	46,846,905.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		32,557,605.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,761,300.00	14,289,300.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>45,919,550.00</b>	<b>69,195,581.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	38,443,330.00	69,194,550.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	38,443,330.00	69,194,550.00

Толбо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,378,850.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,378,850.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	97,370.00	1,031.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	97,370.00	1,031.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<b>5,410,000.00</b>	<b>156,066,760.00</b>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<b>5,410,000.00</b>	<b>56,140,000.00</b>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<b>5,410,000.00</b>	<b>56,140,000.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	5,410,000.00	56,140,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,410,000.00	56,140,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<b>(5,410,000.00)</b>	<b>(56,140,000.00)</b>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	99,926,760.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		99,926,760.00

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,415,384,459.00	1,309,438,445.84	(654,396,593.98)	2,070,426,310.86
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,415,384,459.00	1,309,438,445.84	(654,396,593.98)	2,070,426,310.86
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,415,384,459.00	1,309,438,445.84	(654,396,593.98)	2,070,426,310.86
D08	Тайлант үеийн үр дүн			114,298,195.32	114,298,195.32
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,415,384,459.00	1,309,438,445.84	(540,098,398.66)	2,184,724,506.18

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,265,249,700.00	2,173,730,434.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,265,249,700.00	2,173,730,434.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,191,164,300.00	2,104,535,884.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,565,735,800.00	1,495,735,669.00
210101	Үндсэн цалин	1,290,444,100.00	1,132,194,503.00
210102	Нэмэгдэл	234,389,500.00	322,560,538.00
210104	Урамшуулал	40,902,200.00	40,980,628.00

Толбо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	196,196,700.00	187,445,800.00
210201	Тэтгэврийн даатгал	133,733,300.00	127,783,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	15,615,600.00	14,915,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,493,400.00	11,932,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,123,100.00	2,983,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	31,231,300.00	29,831,300.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	160,906,900.00	160,906,900.00
210301	Гэрэл, цахилгаан	10,952,400.00	13,468,302.00
210302	Түлш, халаалт	148,954,500.00	146,783,598.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	655,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	153,934,700.00	150,269,610.00
210502	Хоол, хүнс	153,934,700.00	150,269,610.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,100,000.00	1,100,000.00
210604	Урсгал засвар	1,100,000.00	1,100,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	10,102,900.00	6,091,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,102,900.00	6,091,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	103,187,300.00	102,986,905.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	88,033,000.00	87,832,605.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,154,300.00	15,154,300.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	74,085,400.00	69,194,550.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	74,085,400.00	69,194,550.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	74,085,400.00	69,194,550.00
<b>13</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	2,265,249,700.00	2,265,248,669.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	2,010,400,000.00	2,010,400,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,010,400,000.00	2,010,400,000.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	254,849,700.00	254,848,669.00
132001	Орон нутгийн төсвөөс	254,849,700.00	254,848,669.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		91,518,235.00
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>		
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	110.00	110.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	69.00	69.00
620003	Үйлчлэх ажилтан	40.00	40.00

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	-
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	-
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	-
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	8,408,525.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	8,408,525.00

Толбо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		8,408,525.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		8,408,525.00

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

#### *Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар*

Толбо сумын Ерөнхий боловсролын сургуулийн зорилго нь: Хүүхдийн хөгжлийг дэмжих суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, амжилттай суралцахад бүх талын хамтын ажиллагаа, оролцоог хангаж хичээл, сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах

Дээрх зорилгынхоо хүрээнд дараах зорилтыг тавьж ажилласан байна. Үүнд:

- Багш, ажилчдын ажлын хариуцлагыг чангатгаж хууль дүрмийн дагуу хариуцлага тооцох.
- Сургалтын хоцрогдлыг арилгах тусгай төлөвлөгөө гаргаж, сургалтын чанарт ахиц гаргах
- Сонгон судлах хичээлийг чанартай зохион байгуулж ЭЕШ-ын дүнгээр 2 байраар урагшлуулах.
- Дотуур байрны сурагчдад тавих хараа хяналтыг сайжруулах, мэргэжлийн багш нар болон эцэг эх, асран хамгаалагчтай нь хамтран ажиллах.
- Багш ажилтанд стрессээс сэргийлэх сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, ажлын байранд эерэг уур амьсгал бүхий байгууллагын соёл бүрдүүлэх.
- Цахим хичээл зохион байгуулах орчин бүрдүүлэхэд эцэг эх, асран хамгаалагчдыг нь татан оролцуулах, хамтран ажиллах.
- Сургууль завсардахаас сэргийлэх, айдас түгшүүр, сэтгэл зовнил, стрессгүйгээр суралцах, хөгжихөд дэмжлэг үзүүлэх эрүүл, аюулгүй амьдрах зөв дадал хэвшүүлэх.
- Багш нарын арга зүйг дээшлүүлэх

Тус сургууль нь хүүхдүүдэд бага, суурь, бүрэн дунд боловсрол мөн насан туршийн боловсрол эзэмшүүлдэг чиг үүрэг бүхий байгууллага юм.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

#### *Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар*

Толбо сумын Ерөнхий боловсролын сургууль нь үйл ажиллагаандаа Боловсролын тухай хууль, Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Шилэн дансны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажилласан байна.

Тус байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Толбо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Толбо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Толбо сумын Ерөнхий боловсролын сургууль нь НББ-ын бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөж ажилласан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Толбо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 111.7 сая төгрөгөөр буюу 5.4 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	99,926.8	99,926.8
Авлага	394.2	329.1	(65.1)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	153,470.3	133,689.4	(19,780.9)
Үндсэн хөрөнгө	1,919,155.6	1,950,779.3	31,623.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,073,020.1</b>	<b>2,184,724.5</b>	<b>111,704.4</b>
Өр төлбөр	2,593.8	-	(2,593.8)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,070,426.3	2,184,724.5	114,298.2
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>2,073,020.1</b>	<b>2,184,724.5</b>	<b>111,704.4</b>

Дээрх хүснэгтээс харахад дараах данснуудад нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Мөнгөн хөрөнгийн данс оны эхэнд үлдэгдэлгүй байсан ба оны эцэст 99.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан ба 91.5 сая төгрөг байгууллагын төрийн сангийн харилцах, 8.4 сая төгрөг нэмэлт дансны үлдэгдэл байна.

Толбо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Авлагын дансны үлдэгдэл 0.3 сая төгрөг байгаа нь ажиллагсадтай холбоотой авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 133.7 сая төгрөг болж 19.8 сая төгрөгөөр буурсан. Төсвийн хөрөнгөөр 249.2 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, аймгийн Боловсролын газар болон төрийн бус байгууллагаас 5.0 сая төгрөгийн аж ахуйн материал, туслах аж ахуйгаас 3.0 сая төгрөгийн төлийн орлого болон хүнсний орлого бүгд 257.2 сая төгрөгийн бараа материалыг орлого авч данс бүртгэлд тусган, 259.7 сая төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1950.8 сая төгрөг болж 31.6 сая төгрөгөөр өссөн нь 56.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авч, Болосролын яамнаас 24.1 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга, ном, сумын ОНХСангаас 9.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж, хувь хүмүүсээс хандиваар 7.3 сая төгрөгийн тавилга, эд хогшил бүгд 41.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсантай холбоотой байна.

Тайлант онд 114.3 сая төгрөгийн үр дүнтэй ажилласантай холбоотой Засгийн газрын хувь оролцоо данс 114.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 2066.2 сая, нийт зарлагыг 2066.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 9.4 сая, бараа үйлчилгээний бусад зардал 91.1 сая, бусад урсгал шилжүүлэгтөгрөгөөр 25.7 сая төгрөгөөр тус тус нэмж цалин, НДШимтгэлийн зардал 0.2 сая, хангамж бараа материалын зардлыг 17.5 сая, норматив зардал 18.5 сая, томилолт, зочны зардал 0.4 сая төгрөгөөр тус тус бууруулж, нийт зардлыг 2269.8 сая төгрөгөөр баталсан нь төсвийн төслөөс 203.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Толбо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны анх батлагдсан төсөв 1726,3 сая төгрөг ба тодотгосон төсөв 2269.8 сая төгрөг байна. Тодотгосон төсөв нь анх баталсанаас 543,5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Үүнд: Цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 471,5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, бараа үйлчилгээний бусад зардал 60,0 сая төгрөгөөр нэмж тодотгосон байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх Ерөнхий боловсролгэсэн 1 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2010.4 сая төгрөгийг улсын төсвөөс, 254.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүгд 2265.2 сая төгрөгийг санхүүжүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2010.4 сая, орон нутгийн төсвөөс 254.8 сая бүгд **2265.2** сая төгрөгийн санхүүжилт олгож гүйцэтгэл 100 байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 95.6 хувь 2173.7 сая төгрөг ба хэмнэгдсэн 91.5 сая төгрөгийг байгууллагын харилцах дансны үлдэгдэлд байна.

**Толбо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Төсвийн гүйцэтгэлийг зардал бүрээр задалж харуулахад цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардал 1495.7 сая, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал 187.4 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 160.9 сая, нормативт зардал 150.3 сая, эд хогшил, урсгал засварын зардал 1.1 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 6.1 сая, бусад бараа үйлчилгээний зардал 102.9 сая бүгд 2173.7 сая төгрөг байна.

Нийт төсвийн зарлагын 68.8 хувийг цалингийн зардал, 8.6 хувийг нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 0.1 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, 6.9 хувийг норматив зардал, 7.1 хувийг эд хогшил, урсгал засварын зардал, 0.3 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, 4.7 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 3.2 хувийг бусад урсгал шилжүүлэг эзэлж байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Байр ашиглалтын үйлчилгээ	4,041.1	4,041.1	-	100%
2	Сургалт семинар	2,020.6	2,020.6	-	100%
3	Хоригдлуудын ЭМДШимтгэл	4,647.3	4,647.3	-	100%
4	үдийн цай хөтөлбөр	74,085.4	69,194.6	(4,890.8)	93%
5	Дотуур байрны үйлчилгээ	295,602.8	291,924.9	(3,677.9)	99%
6	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	55,445.0	55,270.0	(175.0)	100%
7	Боловсролын байгууллагын багш,	9,092.6	9,080.0	(12.6)	100%
8	Боловсролын стандарт, сургалты	1,349,565.4	1,266,803.5	(82,761.9)	94%
9	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	215,899.8	215,899.8	-	100%
10	Нийтлэг үйлчилгээ	254,849.7	254,849.7	-	100%
	<b>Дүн</b>	<b>2,265,249.7</b>	<b>2,173,731.5</b>	<b>(91,518.2)</b>	<b>96%</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд туслах аж ахуйд байгаа малыг худалдсанаас 7.4 сая, аймгийн Болосролын газраас аймгийн хэмжээний ерөнхий боловсролын шалгалтаас аймагт 8-р байр, сумуудаас 1-р байр эзэлсэний шагналд олгосон 1.0 сая бүгд 8.4 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч дансны нэмэлт дансны үлдэгдэлд бүртгэсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

**3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Толбо сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Толбо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий ймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Манаргүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Толбо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 07 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1850.9 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 29.6 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзэв.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой төсвийг хэмнэх талаар 29 арга хэмжээний хэрэгжилтийг шалгаж үзэхэд алдаа зөрчил илрээгүй байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Толбо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Толбо сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2022 онд нийт 2265.2 сая төгрөгийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100% байна. Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг байршуулаагүй байна.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн төсвийн зарцуулалт нь Төсвийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Толбо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудит хийгдээгүй байна.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын холбогдох заалтыг зөрчиж 1.4 сая төгрөгийн тавтлга худалдан авсан, зөрчлийг арилгуулах албан шаардлага өгсөн ба биелэлтийг хангаж, биелэлтийг албан тоотоор ирүүлсэн байна.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарал хандуулах зүйл гараагүй. Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалж Толбо сумын ЕБ-ын сургуулийн төсвийн болон орон нутгаас авсан санхүүжилтийн зарцуулалтын тооцоог бүрэн шалгах боломжгүй, зөвхөн санхүүгийн тайлан гаргалтыг шалгаж баталгаажууллаа.

### **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 32.4 сая төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 0.9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 31.5 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

#### **5.1 Төлбөрийн акт**

Аудитаар 0.9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1. Сургуулийн захирал нь Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны 02 дугаар 01-ны өдрийн А/35, А/10/9 дүгээр хамтарсан тушаалыг баримтлалгүйгээр аймгийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/182 тоот захирамжаар Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Сангийн садын 2010 оны хүчингүй болсон 362/112/183 дугаар хамтарсан тушаалыг үндэслэж 0.9 сая төгрөгийн ур чадварыг нэмэгдлийг авч төсвөөс илүү зарлага гаргасныг нөхөн төлүүлэхээр акт тогтоов.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 5.2 Албан шаардлага

Албан шаардлага байхгүй

## 5.3 Зөвлөмж

### 1. Шилэн данстай холбоотой асуудал

#### 1.1. Илрүүлэлт:

Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан 31.5 сая төгрөгийн 8 шийдвэр гарсныг шилэн дансанд мэдээлээгүй, мэдээлсэн байдлын хэрэгжилт 84.2 хувьтай байна.

#### 1.1 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ыг мөрдөж мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж ажиллах. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
<b>Дүн</b>												

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		/мянган төгрөгөөр/		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хууль журам зөрчсөн	1	880.6	1	880.6								
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>880.6</b>	<b>1</b>	<b>880.6</b>								

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		/мянган төгрөгөөр/		Зөвлөмж	
							Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 8 шийдвэр гарсныг	1	31491.0							1	31491.0

Толбо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

шилэн дансанд мэдээлээгүй								
Дүн	1	31491.0					1	31491.0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>32371.6</b>	<b>1</b>	<b>880.6</b>			<b>1</b>	<b>31491.0</b>